

ЕАБХАБ-ЫН ҮНДЭСТЭН ДАМНАСАН АЮУЛ ЗАНАЛХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Цагдаагийн стратегийн асуудал хариуцсан алба (ЦСАХА)

Мэдээлэлд суурилсан цагдаагийн ажиллагаа Хариу арга хэмжээ авхаас урдчилан арга хэмжээ авахруу

ЕАБХАБ нь Мэдээлэлд суурилсан цагдаагийн ажиллагаа (МСЦА)-г хууль сахиулах үйл ажиллагааны орчин үеийн, идэвхитэй хандлага болгон дэмжиж ажилладаг.

МСЦА нь өнөөгийн хууль сахиулах үйл ажиллагаанд тулгарч буй хоёр гол

бэрхшээлд анхаарлаа хандуулдаг. Үүнд гэмт хэргийн улам бүр ээдрээтэй,

үндэстэн дамнасан шинж чанартай болж байгаа байдал болон төсвийн байгууллагын санхүүгийн үр ашгийг дээшлүүлэхийг олон нийтийн зүгээс шаардаж буй явдал орж байна.

МСЦА-ны гол үндэс нь мэдээлэл (тоон ба бусад) бөгөөд энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахад шийдвэрлэх хүчин зүйл болдог.

МСЦА нь цуглуулсан мэдээллийг удирдан зохион байгуулах, дүн шинжилгээ хийх зорилготой бүтэц болон үйл ажиллагааны дүрэм журмыг бий болгох, эдгээр зохицуулалт нь үндэсний ба олон улсын хууль тогтоомж, мэдээллийн хамгаалалт, хүний эрхийн стандартад нийцсэн байхад анхаарна.

Сүүлийн үед зохион бай

гуулалттай гэмт хэрэг, терроризмтой тэмцэхэд бүх түвшний байгууллага албанаас мэдээлэл авч, хоорондоо хуваалцаж, хамтран дүн шинжилгээ хийж ажиллах нь хамгийн үр дүнтэй арга болжээ.

МСЦА нь өгөгдөл, мэдээллийг системтэй цуглуулж, дүн шинжилгээ хийснээр дараах үр дүнд хүрэхэд тустай. Үүнд:

- Стратегийн болон үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилгыг тодорхойлох;
- Бодлого, стратеги, үйл ажиллагаа, мөрдөн байцаалтын талаар шийдвэр гаргах;
- Хүн хүч, санхүү, бусад нөөцийн зохистой хуваарилалтыг хангах.



МСЦА-г амжилт-тай болгох уг-твар нөхцлүүд:

- Олон улсын стандарт, хүний эрх, мэдээллийг хамгаалах зарчимд нийцсэн үндэсний хууль эрх зүйн тогтолцоо;
- Улс төрийн дэмжлэг, удирдлагын зүгээс дэмжиж манлайлах;
- Эрүүгийн тагнуулын мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвартай ажилтнууд болон шийдвэр гаргах, төлөвлөгөө хийхдээ эдгээрийг оновчтой ашигладаг удирдлагын баг;
- Хууль сахиулах байгууллагын ажилтнуудын “мэдэх хэрэгтэй” гэсэн хандлага, сэтгэлгээг “хуваалцах, хамтрах хэрэгтэй” болгон өөрчилж хувиргах;
- МСЦА-ны хүрээнд үндэсний, бүс нутгийн, орон нутгийн түвшинд ашиглах мэдээллийн сан, мэдээлэл технологийн си-

стемүүдийг бий болгох;

- Дотоод ба гадаад мониторинг, хяналтын механизм;
- Бүс нутгийн ба олон улсын түвшинд хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл хуваалцах.

ЕАБХАБ-ын Мэдээлэлд суурилсан цагдаагийн ажиллагааны талаарх гарын авлага

ЕАБХАБ-ын Үндэстэн дамнасан аюул заналхийлэлтэй тэмцэх газрын Цагдаагийн стратегийн асуудал хариуцсан алба нь ЕАБХАБ-ын Мэдээлэлд суурилсан цагдаагийн ажиллагааны талаарх гарын авлага боловсруулсан. Энэхүү гарын авлагад ЕАБХАБ-ын бүс нутагт МСЦА-г хэрэгжүүлэхэд баримтлах нийтлэг, уялдаа холбоотой арга зүйг танилцуулсан байна. Үүнд:

- МСЦА нь хууль сахиулах байгууллагын орчин



үеийн хандлага загвар болохын учир шалтгаан, үндэслэлүүд;

- МСЦА-г хэрэгжүүлэхтэй холбоотой хүний эрх, мэдээллийг хамгаалах зэрэг чухал сэдвүүдийг багтаасан;
- Өгөгдөл, мэдээлэлд хэрхэн дүн шинжилгээ хийж, нотолгоонд суурилан шийдвэр гаргахдаа ашигладаг стратегийн болон үйл ажиллагааны тайлан гаргах талаар тайлбарласан;
- Эрүүгийн тагнуулын хэлтэс, шийдвэр гаргах механизмд шаардлагатай практик зөвлөмж, наад захын стандар-

туудыг танилцуулсан;

- МСЦА нь олон нийтийн цагдааг дэмжиж, терроризмд турхирч, хүчирхийлэл дагуулж буй экстремизм, радикалчлалтай тэмцэх үр дүнтэй арга болохыг тайлбарласан.

Сургалт

Гарын авлагад үндэслэн Цагдаагийн стратегийн асуудал хариуцсан алба наас ЕАБХАБ-аас санал болгосон МСЦА-ны загвар, түүнийг хууль сахиулах системийг бэхжүүлэхэд хэрхэн ашиглах талаар танилцуулах бүсийн ба үндэсний хэмжээнд явуулах сургалт, семинарыг төлөвлөсөн.

Мэдээлэлд суурилсан цагдаагийн ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл

Энэхүү гарын авлагыг та www.osce.org/chairmanship/327476 хаягаас татаж авах боломжтой бөгөөд МСЦА-ны гол элементүүдийг тайлбарласан видеог www.osce.org/secretariat/403085 хаягаар орж үзнэ үү.



Олон нийттэй харилцах тус хаягуудаар ЕАБХАБ-ыг дагна уу



ЕАБХАБ-ын Нарийн бичгийн дарга
ЕАБХАБ-ын Үндэстэн Дамнасан
Аюул Заналхийлэлтэй Тэмцэх Газар
Цагдаагийн Стратегийн
Асуудал Хариуцсан Алба
Вальнерштрассе 6
1010 Вена
Австри